



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/105

Мандалговь

Сургалтын төлбөрийн дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 60.1.5, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн 4.1.1.8, 4.1.1.6 дахь заалт, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчнээр бэлтгэгдэж байгаа оюутан болон Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж буй хавсралтад заасан нэр бүхий оюутан, төрийн жинхэнэ албан хаагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сургалтын төлбөрт шаардагдах 13.200.000 (Арван гурван сая хоёр зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100251

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны  
03 дугаар сарын 18 -ны өдрийн 405 дугаар  
захирамжийн хавсралт

СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ ОЮУТАН,  
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Сургалтын төлбөрийн мөнгөн дүн
1	Ц.Уранбямба	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1.620.000
2	Г.Зоригт	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсийн дарга	1.620.000
3	С.Энхжаргал	Аймгийн ЗДТГ-ын ерөнхий санхүүч	1.620.000
4	Х.Цогзолмаа	Соёлын хэлтсийн ахлах мэргэжилтэн	1.620.000
5	С.Долгорсүрэн	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга	1.620.000
6	М.Дашхүү	ОХУ-ын А.А.Ежевскогын нэрэмжит Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутан	2.600.000
7	Ш.Цэрэндаш	Аймгийн музейн сан хөмрөгч	2.500.000
	<b>Нийт дүн:</b>		<b>13.200.000</b>